



БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, Гучин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн бие, өргөө, унаа халдашгүй дархан байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн нэр төр, халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж, Дөчин хоёрдугаар зүйлд “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тус тус заасан бөгөөд төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, хамгаалалтыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг тогтоосон Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг 1995 онд баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.” гэж тодорхойлж, хурдтай хувиран өөрчлөгдөж байгаа аюулгүй байдлын орчинд нийцүүлэн үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох зорилтыг дэвшүүлжээ.

Тухайлбал, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэлийг хийнэ” гэж, 4.1.3-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно” гэж, 4.1.4-т “Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ.” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-

ны зорилтын 7.3.1-т “Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.” гэж тус тус заасан.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон боловч 2 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөс бусад нэмэлт, өөрчлөлт нь буюу 80 хувь нь тус хуулийн зохицуулалттай холбоотой тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хуулиуд шинэчлэгдсэн, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь 1995 онд анх байгуулагдсанаас хойш 25 жилийн хугацаанд Тагнуулын ерөнхий газрын харьяа байгууллагын хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2020 оноос Засгийн газрын тохируулагч агентлаг болж, чиг үүргээ бие даан хэрэгжүүлж эхэлсэн.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар орсон нэмэлт, өөрчлөлтөөр Төрийн тусгай хамгаалалтын газрыг Засгийн газрын тохируулагч агентлаг болгон зохион байгуулалтын хувьд өөрчилсөн боловч үүнтэй уялдуулан байгууллагын чиг үүрэгтэй холбоотой хуулийн зохицуулалтыг шинэчлээгүй нь тус агентлагаас хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого тодорхойлох болон салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, үүрэг чиглэл өгч, гүйцэтгэлийг хангуулах зэрэг эрх хэмжээг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төрийн тусгай хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай бусад зүйлийн жагсаалтыг Засгийн газраас тогтоохоор заасны дагуу Засгийн газрын 1995 оны 127 дугаар тогтоолоор хуульд заасан Төрийн ордон, Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууцнаас гадна Их тэнгэрийн ам, Их тэнгэрийн амны гүүр, Төрийн тусгай хамгаалалтын газрын гарааш, хүнсний агуулах зэрэг объектуудыг төрийн тусгай хамгаалалтад авахаар тогтоож байсан бол Засгийн газрын 2012 оны 65 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан жагсаалтын дагуу Төрийн тусгай хамгаалалтын байгууллага нь яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газар зэрэг 28 төрлийн барилга, байгууламжийг хамгаалалтаар хангах болжээ.

Ийнхүү 1995 онд тогтоосон төрийн тусгай хамгаалалтад байх объектыг хэт өргөжүүлж, 7 дахин нэмэгдүүлсэн нь төрийн тусгай хамгаалалтын үндсэн чиг үүрэгт хамаарах биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахын зэрэгцээ тусгай хамгаалалтын ач холбогдол, мэргэшсэн байх чадварыг бууруулж, харуул хамгаалалтын чиг үүрэгтэй адилтган үзэхэд хүргэсэн байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсон “төрийн хамгаалалт, түүний онцлог” болон мөн хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд хамгаалалтыг хэрэгжүүлэх хүрээ буюу хамгаалалтад авах албан тушаалтан болон объектийг тодорхойлох нөхцөл, шалгуурыг ойлгомжгүй, хоёрдмол утгатай, өөр хоорондоо зөрчилтэй байдлаар хуульчилсан байна.

Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6.1.5-д “Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн газрын тэргүүн, өөрийн хамгаалалттай ирсэн гадны өндөр, дээд хэмжээний зочин” төрийн тусгай хамгаалалтад байхаар зохицуулсан нь “өөрийн хамгаалалттай ирсэн бүх зочид төлөөлөгч”-ийг Монгол Улсын төрийн тусгай хамгаалалтад авах мэт зөрүүтэй байдлыг үүсгэхээр, мөн хуулийн 6.3-т төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэнийг тогтоох шалгуурыг хэт ерөнхий буюу “Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс” гэж тодорхойлсон, 7 дугаар зүйлд заасан төрийн тусгай хамгаалалтаар хангах олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн гэдэгт ямар арга хэмжээг хамааруулах нь тодорхойгүй зэрэг хийдлийг арилгах шаардлагатай байна.

Түүнчлэн, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар тогтоосон төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бусад хуулиар өргөжүүлэн тогтоодог хуулийн гажуудал бий болж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд Төрийн тусгай хамгаалалтын байгууллага Эрдэнэсийн санг гэрээний үндсэн дээр хамгаалах, Эрдэнэсийн сангийн эрдэнэсийг тээвэрлэх, шилжүүлэх, байршуулах үйл ажиллагааг хариуцах шинэ чиг үүргийг оруулжээ.

Дээр дурдсан хуулийн хэрэгжилтийн хүрээнд үүсээд байгаа гажуудал нь хуулийн зохицуулалтын хийдэлтэй байдал буюу төрийн тусгай хамгаалалтын зорилго, онцлог, хамрах хүрээг төрийн бусад төрлийн хамгаалалтаас зааглан тодорхойлж чадаагүй, хамгаалалт тогтоох шалгуурыг хэт ерөнхий тогтоосон зэрэг нь хамгаалалтад авах объектыг тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч харилцан адилгүй байдлаар тогтоох нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид тавигдах шаардлага, эрх зүйн баталгаатай холбоотой зохицуулалт нь төрийн албаны эрх зүйн шинэчлэлээс хоцорсон төдийгүй сонгон шалгаруулах, томилох журмыг улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчимд нийцүүлэн нарийвчлан зохицуулах шаардлага тулгарч байна.

Тухайлбал, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд “төрийн тусгай хамгаалалтын алба хаагч” гэж зөвхөн хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа төрийн тусгай албан тушаалтныг хамааруулан тодорхойлсноор тус байгууллагад ажиллаж байгаа бусад албан хаагчдын хувьд чиг үүргийн онцлогт нийцсэн нийгмийн баталгаагаар хангагдах боломжгүй байдлыг өөрчилж, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын нийт албан хаагчийн эрх зүйн байдлыг чиг үүргийн онцлогтой нь уялдуулан цогц байдлаар тодорхойлох шаардлагатай байна.

Иймд хуулийн хэрэгжилттэй холбоотой дээр дурдсан хүндрэл бэрхшээлийг арилгах, төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээг Монгол Улсын Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн оновчтой тогтоож, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, албан хаагчид тавих мэргэжлийн чадвар, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх, эрх зүйн баталгааг холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн болон гадаад харилцаанд гарсан томоохон өөрчлөлт, шинэчлэл нь тус хуулийн зохицуулалтыг Хууль тогтоомжийн

тухай хуулийн 25.1.4-т заасны дагуу цогц байдлаар шинэчлэх хууль зүйн шаардлагыг илэрхийлж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол”, мөн хуулийн 25.1.4-т “тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон” тохиолдолд хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хуулийн төслийг бүтцийн хувьд 7 бүлэгтэй байхаар боловсруулж, Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэгт төрийн тусгай хамгаалалт, түүний хамрах хүрээ, зэрэглэл болон хамгаалалтын бүс, хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулж, Гуравдугаар бүлэгт төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зохион байгуулалт, хамтын ажиллагааны эрх зүйн үндэс, бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүлээх үүргийг тогтоож, Дөрөвдүгээр бүлэгт төрийн тусгай хамгаалалтын байгууллага, түүний эрх хэмжээг, Тавдугаар бүлэгт төрийн тусгай хамгаалалтын байгууллагын алба хаагчийн чиг үүрэг, эрх зүйн байдлыг, Зургадугаар бүлэгт төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан албадлага, хүч хэрэглэх үндэслэл, журмыг тогтоож, Долдугаар бүлэгт бусад асуудлыг тус тус тусгана.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний¹ дүгнэлтийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн зорилтыг “төрийн тусгай хамгаалалтын зорилго, хамрах хүрээ, зохион байгуулалт болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн баталгааг тогтоож, хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах” гэж өргөжүүлэн тодорхойлж, хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгана. Үүнд:

1.Төрийн тусгай хамгаалалтыг үндэсний аюулгүй байдал болон төрийн хамгаалалтын бүрэлдэхүүн хэсгийн хувьд зорилго, хамрах хүрээ, хамгаалалтын арга хэлбэр болон баримтлах зарчим зэргийг харилцан уялдаатай байдлаар төрийн бусад хамгаалалтаас ялган тодорхойлно.

2.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй тусгай албаны хувьд төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүргийг Засгийн газрын тохируулагч агентлагийн эрх хэмжээнд шинэчилж, хариуцсан чиглэлийн хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг салбар болон төрийн байгууллага хооронд уялдуулан зохицуулах чиг үүргийг Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан өөрчилнө.

¹ Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2022

3.Төрийн тусгай хамгаалалтад байх субъект, объектыг төрийн тусгай хамгаалалтын зорилготой уялдуулан хамгаалалтад авах шалгуур, үндэслэлийг нарийвчлан тодорхойлж тусгана.

4.“Төрийн тусгай хамгаалалтын бүс”-ийг албан тушаалтан, хүн, барилга, байгууламж, хуралдаан зэрэг хамгаалалтын объектын онцлогийг харгалзан ялгамжтай байдлаар тогтоох бөгөөд барилга байгууламжтай холбоотой төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх хүрээг тодорхой тусгана.

5.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, төрийн бусад байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгана.

6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдлыг нийтлэг болон чиг үүргийн онцлог, албан тушаалын ангиллыг харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба “мэргэшсэн, тогтвортой байх”, “улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх”, “төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах” зарчим болон нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан шинэчилж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах эрх зүйн үндэслэлийг шинэчлэн тогтооно.

7.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр “төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, алба хаах насны дээд хязгаарыг тогтоох, цэргийн цол хэрэглэх”-тэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж дүгнэсний дагуу төрийн тусгай хамгаалалтын алба хаагчдын үүрэг, хариуцлага, ёс зүйг тусгай албаны чиг үүргийн онцлог, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн шинэчлэн тогтооно.

8.Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглах боломжийг бүрдүүлж, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэлийг ялгаатай байдлаар хуулийн төсөлд тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

-Төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх хүрээ хязгаарыг тодорхой болгосноор Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирлыг эрхэмлэх, шуурхай, тасралтгүй байх, төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчмыг хангахаас гадна хамгаалалтын хүч, хэрэгслийн оновчтой хуваарилалт, төсвийн зардлыг зохистой хэрэглэх боломж бүрдэнэ.

-Төрийн тусгай хамгаалалтын байгууллага болон түүний удирдлагын чиг үүрэг, бүрэн эрх, алба хаагчийн эрх, үүрэг, төрийн тусгай хамгаалалтад оролцогч бусад төрийн байгууллагын чиг үүрэг, иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүргийг төрийн тусгай хамгаалалтын байгууллагын үйл ажиллагааны онцлог, төрийн тусгай хамгаалалтыг иж бүрэн байх зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

-Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн эрх зүйн байдал сайжирч, ажил үүргээ ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагатай, чин шударгаар гүйцэтгэх албан

хаагчдаас бүрдсэн төрийн тусгай хамгаалалтын алба бүрдэхэд чухал түлхэц болно.

-Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, техник, албаны нохой зэргийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгон хуульчилснаар алба хаагчид, мөн бусад хууль хэрэглэгч болон эрсдэл бүхий иргэдэд ойлгомжгүй байдал үүсгэхээс урьдчилан сэргийлж, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн ойлгомжгүй, тодорхойгүй зохицуулалтуудын хийдэл арилж, хууль хэрэгжилтийн түвшинд эерэг үр дагавар үүсэх боломжтой болно.

-Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчлэл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн байгууллагын орон тоо нэмэгдэхгүй, орон тооны цомхотгол хийгдэхгүй.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу тусгайлан боловсруулж, улсын төсвөөс гарах зардлыг хэмнэх боломжийг харгалзан хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хуультай нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан 1995 онд батлагдсан Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан боловсруулна.